



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Г 2025 оныг “Иргэдийн итгэлийг хүлээсэн”  
төрийн үйлчилгээний жил” болгон зарлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор 2025 оныг “Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил” болгон зарласугай.

2.“Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой зорилт, арга хэмжээгээр тусгаж, хэрэгжүүлж ажиллахыг нэгжийн дарга, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.“Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор боловсруулан батлуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Энхболд)-т даалгасугай.

5.“Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны явц, үр дүнг улирал тутам Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулж, олон нийтэд тогтмол мэдээлж, сурталчилан ажиллахыг Ажлын хэсэг (Б.Энхболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА  А.ЭНХМАНЛАЙ



1525010044